



ИРГЭНИЙ ШИНЖЛЭХ УХААНЫ АРВАН ЗАРЧИМ

Иргэний шинжлэх ухаан нь янз бүрийн нөхцөл байдал болон салбаруудад тохируулан хэрэглэж болох уян хатан ойлголт юм. Лондоны Байгалын Түүхийн Музей тэргүүлсэн **Европын Иргэний Шинжлэх Ухааны Нийгэмлэгийн** (European Citizen Science Association) *‘Шилдэг туршлагыг хуваалцах ба чадварыг хөгжүүлэх’* ажлын групп тус Нийгэмлэгийн олон гишүүдийн санал сэтгэгдлийг сонсож зарим нэгэн гол зарчмуудыг тодорхойлох зорилгоор доорх мэдэгдлийг хийсэн болно. Эдгээр зарчмууд нь иргэний шинжлэх ухааны хувьд практикийн суурь болно гэж манай нийгэмлэг итгэж байна.

- 1. Иргэний шинжлэх ухааны төслүүд нь шинэ мэдлэг ба ойлголтыг бий болгодог шинжлэх ухааны үйл ажиллагаанд иргэдийг идэвхтэй татан оролцуулна.** Иргэд нь төсөлд өөрийн хувь нэмрээ оруулах, хамтран ажиллах эсвэл төслийг гардан удирдсанаар чухал үүрэг гүйцэтгэж болно.
- 2. Иргэний шинжлэх ухааны төслүүд нь шинжлэх ухаанд бодит хувь нэмрээ оруулна.** Жишээлбэл, судалгааны асуултанд хариулах эсвэл хамгаалах үйл ажиллагаа явуулахад болон удирдлагын шийдвэр гаргахад, байгал орчны бодлого боловсруулахад мэдээллээр хангах хувь нэмэртэй.
- 3. Мэргэжлийн эрдэмтэн судлаачдын хувьд ч, иргэний судлаачдын хувьд ч иргэний шинжлэх ухааны төсөлд оролцох нь ашигтай.** Жишээлбэл, судалгааны үр дүнгээ хэвлэн нийтлүүлэх, суралцах боломж, хувийн таашаал, нийгмийн ашиг зэрэг байж болно. Түүнчлэн орон нутаг, улс болон олон улсын түвшинд тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд шаардлагатай шинжлэх ухааны нотолгоонд хувь нэмрээ оруулах замаар сэтгэл ханамжаа дээшлүүлж чадна. Цашилбал, эдгээрээр дамжуулан бодлогонд нөлөөлөх боломж ч байна.
- 4. Иргэний судлаачид нь хэрэв хүсвэл шинжлэх ухааны янз бүрийн үе шатанд оролцож болно.** Үүнд судалгааны асуулт боловсруулах, арга зүйг боловсруулах, өгөгдөл цуглуулах болон дүн шинжилгээ хийх, үр дүнг мэдээлэх зэрэг багтаж болно.
- 5. Иргэний судлаачид нь оруулсан хувь нэмрийнхээ талаар төслийн зүгээс мэдээлэл авч чадна.** Жишээлбэл, өөрийн бүрдүүлсэн өгөгдлүүд хэрхэн ашиглагдсан болон судалгааны ажил, бодлого боловсруулалт, нийгэмд ямар үр нөлөөтэй байсан талаар мэдэж авч чадна.
- 6. Иргэний шинжлэх ухаан нь бусад шинжлэх ухааны судалгаануудтай нэгэн адил хязгаарагдмал болон өрөөсгөл талуудтай. Эдгээрийг байнга анхааралдаа аван хяналт тавьж байх шаардлагатай.** Хэдийгээр тийм боловч иргэний шинжлэх ухаан нь уламжлалт судалгааны арга барилаас ялгаатай нь жирийн иргэд судалгааны ажилд оролцох боломжийг нэмэгдүүлэх, шинжлэх ухааныг чөлөөтэй болгох боломжийг олгоно.

7. Иргэний шинжлэх ухааны төсөл нь өгөгдөл болон мета өгөгдлийг олон нийтэд ашиглагдахаар нээлттэй болгож, мөн түүнчлэн үр дүнгээ аль болох ямар нэгэн хязгаарлалтгүй нээлттэй хэлбэрээр ил болгоно. Өгөгдлийг төслийн явцад эсвэл төсөл дууссаны дараа нийтэд ил тод болгоно. Харин аюулгүй байдал болон хүний хувийн мэдээллийг хөндөх тохиолдолд өгөгдлийг нийтэд ил тод болгохгүй.
8. Иргэний судлаачдын оруулсан хувь нэмэр нь төслийн үр дүн болон хэвлэл бүтээлд тусгагдана.
9. Иргэний шинжлэх ухааны программууд нь шинжлэх ухааны ололт, өгөгдлүүдийн чанар, оролцогчдын туршлага, нийгэм ба бодлогод үзүүлсэн нөлөөгөөрөө үнэлэгдэнэ.
10. Иргэний шинжлэх ухааны төслийн удирдагч нь зохиогчийн эрх, оюуны өмч, өгөгдлийг хуваалцах гэрээ, нууцлал хамгаалалт, өгөгдлийн эх сурвалж, цаашилбал төслийн үйл ажиллагааны байгал орчинд үзүүлэх нөлөө зэрэг янз бүрийн хууль болон ёс зүйн асуудлыг харгалзан үзнэ.

2023 он 3 сар, Ёкохама хот • Мюнхен хот